

22. Эзэн минь, цаг агаарын хүнд байдлаас болж гэрт нь хохирол амссан Кабилийн хяналтын багийн гишүүний гэр бүлийг хүчирхэгжүүлж, тэжээгээрэй. Мөн итгэлийнхээ улмаас нийгэмд гадуурхах хандлага гардаг тул тэдний хамгаалагч болоорой. (Дуу. 91:15)

23. Тэнгэрлэг Эцэг минь ээ, бид Төв Азийн гэр бүлүүд, ихэнх тохиолдолд аль хэдийн итгэсэн эмэгтэйчүүдийн эхнэр, нөхөр, хүүхдүүд Есүс Христийн сайн мэдээг сонсоод, сүм цуглаанд ирээсэй гэж гуйж байна. (Үйлс 16:31)

24. Эзэн минь, үнэнч бус, хариуцлагагүй нөхөртэй Төв Азийн эмэгтэйчүүдийг тайвшруулж, зоригжуулаач. Гэр бүлийн дарамтыг үл харгалзан Христэд итгэгч нөхөртэй гэрлэх хүч болон мэргэн ухааныг эдгээр эмэгтэйчүүдэд өгөөч. (Ром. 12:12)

25. Манай Кабилийн баг хамт олон бусад итгэгчидтэй харилцах ямар ч боломжгүй байдагч сонсогчдоос урам зориг хайрлаж байгаад Бурхан таныг магтъя. (Дуу. 99:5)

26. Эзэн минь ээ, бид хэлмэгдүүлэлт, хавчлага, нийгмийн дарамтад өртөж буй Төв Азийн эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Тэднийг хүчтэй байлгаж, хамгаалаарай! (Жиш. 15:2)

27. Бурхан минь, өөр ажилд орох эрхгүй, боломж ч үгүй, нөхрийнхөө эцэг эхийн гэрт үйлчлэгчээр амьдардаг Төв Азийн залуу бүсгүйчүүдэд хүч чадал, итгэл найдвар хайрлаач. (Иер. 29:11).

28. Өршөөнгүй Аав аа, Хойд Африкт байгаа итгэгчдийг байцааж мөн хавчиж дарамталж байгаа тул байнгын стрессээс хамгаалаарай. (Мат. 5:11-12)

29. Бурхан минь, бид Хойд Африк дахь хүнсний хомсдолыг зогсоохын төлөө залбирч байна. Энэ асуудлыг шийдэж чадах хүмүүсээр хангаж, мэргэн ухаан өгөөрэй. (Дуу. 146:7)

30. Эзэн Бурхан минь, Төв Азийн Христэд итгэгч болсон ч хамаатан садныхаа дарамтад өртөх эрсдэлтэй учраас итгэлээ ил тод хэлж чадахгүй байгаа эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлээч. (Дуу. 91:2)

31. Аав аа, Хойд Африкийн зарим хэсэгт засгийн газрууд COVID-ийн хамгийн хатуу хязгаарлалтыг хөнгөвчилж байгаад бид таны нэрийг магтаж байна. (Дуу. 71:14)

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다



Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



2022. 10. Маш цөхөрмөөр нөхцөлд орохоороо хүмүүс найдвараа алддаг. Тэдэнд бусдын тусламж хэрэгтэй.

Бурхан биднийг хэрэглэхийг хүсдэг. Ислам шашинтай орнуудын эмэгтэйчүүд Бурханы дотроос өөрийн мөн чанараа зөв ойлгож, амьдрал нь өөрчлөгдөөд зогсохгүй нийгэмдээ олон өөрчлөлтүүдийг бий болгохын төлөө залбирч байна.

TWR Korea 북방선교방송

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

1. Хойд Африк дахь олонхын шашны удирдагчдын эсэргүүцэлтэй тулгарсан ч "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг үргэлжлүүлэн сонсогчдод хүргэсээр байгаад Бурхан танд баярлалаа. (1 Тесалоник 5:16-18).

2. Аав аа, Төв Ази дахь ихэнх гэр бүлүүдийн нөхрүүд гадагшаа ажил хийхээр явж, эхнэрүүд нь хүүхдүүдтэйгээ үлдэж байгаа тул бид тэдгээр гэр бүлүүдийн эв нэгдлийн төлөө залбирч байна. (Дуу. 133:1).

3. Тэнгэрлэг Эцэг минь ээ, бид танаас Төв Азийн Христэд итгэгч эмэгтэйчүүдийг аврагдаагүй гэр бүл, найз нөхдөдөө таныг гэрчилж чадах сүнслэг хүч чадлыг өгөөсэй гэж гуйн залбирч байна. (Үйлс 1:8)

4. Эзэн минь, Хойд Африкт эрх баригчдын дайсагнал ихсэж байгаатай холбогдон манай Кабилийн баг, бусад Христэд итгэгчид болон гадаадын иргэдтэй харьцдаг хүмүүсийг хамгаалаач. (Дуу. 91:1)

5. Аав аа, Төв Азийн итгэгчдийг өөр өөр тосгоноос цуглуулж таны тухай илүү ихийг мэдэж, бие биенээ дэмжиж, сайн мэдээ хуваалцах боломжийг олгооч. (Мат. 18:20)

6. Эзэн минь, эцэг эхчүүд нь гадаадруу ажил хайж байгаад, одоо хилийн хоригоос болж гэр бүлрүүгээ буцаж чадахгүй байгаа төв азийн эцэг эхээ санасан хүүхдүүдийн зүрх сэтгэлийг тайвшруулаач,. (Дэд хууль 31:8)

7. Тэнгэрлэг Эцэг минь ээ, манай Кабилийн багийнхны "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийн сонсогчдын асуултад хариулж, тэдэнд таныг ойлгож, зүрх сэтгэлдээ хүлээн авах мэргэн ухааныг өгөөч. (Ис. 33:6)

8. Бурхан минь, Төв Азид салсан эцэг эхчүүд нь дахин гэрлэх үед ард нь орхигдож байгаа хүүхдүүдийг хамгаалж, зүрх сэтгэлийн хамгаалж тайвшруулж өгөөч. (Мат. 18:10)

9. Эзэн Бурхан минь, Төв Азийн итгэгчдийн амьдрал маш хэцүү, стрессээр дүүрэн байдаг тул Есүсээс хүч чадлыг олж аваасай гэж бид залбирч байна. (Дуу. 28:7)

10. Аав аа, Курд хэл дээр ажилладаг Курманжи зохион байгуулагчиг "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийн зохиолийг судалж, бичиж байхад нь мэргэн ухаан, бүтээлч сэтгэлгээг өгөөч. (Жиш. 35:35)



11. Эзэн минь, Төв Азийн эхчүүд таныг өөрийн Аврагчаар хүлээн авч, үр хүүхдийнхээ амьдралд бурханлаг итгэлийн суурийг тавих болтугай. (Сургаалт үгс 22:6).

12. Бурхан минь, Төв Азийн соёлын өөрчлөлтөд нөлөөлж чадах хүмүүсийн зүрх сэтгэлд хүрч өгөөч. Ийм хатуу хязгаарлалтад байгаа эмэгтэйчүүдэд тусалж, тэднийг хүчирхэгжүүлэгч. (2 Коринт 3:17)

13. Эзэн минь, бид Хойд Африкийн багтай нэгдэж, өнгөрсөн нэг жилийн хугацаанд амьдралаа Христэд өгсөн мөн амьдралаа дахин зориулсан бүх хүмүүсийн төлөө Таныг магтан дуулж байна! (Дуу. 9:1)

14. Тэнгэрлэг Эцэг минь, гэр бүл салалтын түвшин өндөр байгаагаас болж ганцаараа хоцорсон Төв Азийн эмэгтэйчүүд, эхчүүдийн сэтгэлийг тайвшруулж, ажил хөдөлмөр эрхлүүлээрэй. (Филиппой 4:19)

15. Бурхан Аав аа, эрх чөлөөг авчирдаг таны үнэнийг Төв Азийн эмэгтэйчүүд хүлээн аваасай гэж бид залбирч байна. Тэдний үнэ цэнийг таны нүдээр харахад тусал. (Еф. 2:10)

16. Эзэн Бурхан минь, бид Хойд Африкийн үйлчлэлийн багуудын эрүүл мэндийн төлөө залбирч байна. Тэдэнд гэр бүлийн амьдрал, үйлчлэлээ таны хүссэнээр ухаалаг зохицуулах болтугай. (Жиш. 23:25)

17. Аав аа, Төв Азийн эмэгтэйчүүд стресст автсан үедээ амиа хорлох бодол санаагаа няцааж, оронд нь тэд танд өөрийн бодлоо илэрхийлэх болтугай гэж залбирч байна. (2 Коринт 10:5)

18. Бурхан Аав аа, Төв Азийн гэр бүлүүдээс архинд донтсон гишүүдийг эдгээхийг бид танаас хүсэж байна. Донтсон хүмүүс Есүсийн нэрээр эрх чөлөөг олох болтугай. (Иаков 5:16)

19. Хүчирхийлэл, гэр бүл салалт, хоол хүнсний хомсдол зэрэг хүнд хэцүү нөхцөлд байсан Кабилийн эмэгтэйчүүдэд тусалж чадсан Хойд Африкийн багуудын төлөө Бурхан таныг магтаж байна. (Дуу. 46:1)

20. Өө, Эзэн минь, Төв Азийн орнуудад гэр бүл салалт их байна. Эдгээр хосууд тантай болон бие биетэйгээ эвлэрэх болтугай. (Еф. 4:32)

21. Тэнгэрлэг Эцэг минь ээ, Төв Азийн эмзэг бүлгийн өнчин охидод Библийн үнэнийг сонсож, таны удирдамжийг хүлээн авах боломжтой орон нутгийн сүмүүдтэй холбогдоход туслаач. (Иаков 1:27)